

БАТЛАВ  
 ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
 ДАРГА  
 РОТГОНЖАРГАЛ

“ГААЛИЙН БАЙГУУЛЛАГЫН 2024 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ”-НИЙ БИЕЛЭЛТИЙГ  
 ЭРЧИМЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэх нэгж	Хариуцах нэгж	
1	Улсын хилээр нэвтрүүлэх эм, эмнэлгийн хэрэгсэлд тавих хяналтыг сайжруулах, гаалийн байгууллагад эм, эмийн бүтээгдэхүүнийг үнэн, зөв мэдүүлэх зорилгоор зөвлөмж гаргах, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газартай хамтран “Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдал, хангамж, хүртээмжийг нэгдсэн цахим тогтолцоогоор хянах” боломжийг бүрдүүлэх.	- Улсын бүртгэлд бүртгэгдсэн эм, эмийн бүтээгдэхүүний ангиллын код, барааны бичиглэл бүхий зөвлөмж, мэдээллээр гаалийн харилцаанд оролцогчдыг ханган, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газраас олгодог мэдүүлэг /лиценз/ дэх мэдээллийг Licensed системээс СЕРS систем рүү автоматгаар real time байдлаар хүлээн авч, гаалийн бүрдүүлэлтийг хийдэг болсноор бичиг баримтын бүрдүүлэлтэд зарцуулах цаг хугацааг хэмнэх, хуурамч, дуураймал эм улсын хилээр нэвтрүүлэхээс урьдчилан сэргийлэх боломж бүрдэнэ.	- Хяналт, бүрдүүлэлтийн газар, - Барааны ангилал, үнэлгээний хэлтэс, - Санхүү, хөрөнгө оруулалтын газар, - Хорио цээрийн хэлтэс, - Мэдээллийн технологийн газар, - Олон нийтэй харилцах алба, - Харьяа гаалийн газар, хороод	Хяналт, бүрдүүлэлтийн газар
2	Солгууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидаан солгуураахтай тэмцэх тухай хуулийн 38.3 дахь заалтын хэрэгжилтийг хангах.	1. Импортлогч нараас: -гаалийн байгууллагад бүрдүүлж, илгээдэг бичиг баримтын тоо буурна; -OATТ авахаар TEG-г хүсэлт гаргаж, баталгаажуулалт хийлгэх хугацааг багасгана. 2. Хилээр оруулсан солгууруулах ундааны хөдөлгөөнийг эцсийн хэрэглэгч хүртэл хянах системийн суурь тавигдана. 3. Онцгой албан татвартай барааны мэдээллийг ХХААХҮД, Татварын Ерөнхий газартай солилцсоноор хяналтыг сайжруулна.	- Хяналт, бүрдүүлэлтийн газар, - Санхүү, хөрөнгө оруулалтын газар, - Мэдээллийн технологийн газар, - Олон нийтэй харилцах алба, - Харьяа гаалийн газар, хороод	Хяналт, бүрдүүлэлтийн газар

БАТЛАВ  
ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ДАРГА Р.ОТГОНЖАРГАЛ

**“ГААЛИЙН БАЙГУУЛЛАГЫН 2024 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ”-НИЙ БИЕЛЭЛТИЙГ  
ЭРЧИМЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хүрэх үр дүн	Хэрэгжүүлэх нэгж	Хариуцах нэгж
1	Улсын хилээр нэвтрүүлэх эм, эмнэлгийн хэрэгсэлд тавих хяналтыг сайжруулах, гаалийн байгууллагад эм, эмийн бүтээгдэхүүнийг үнэн, зөв мэдүүлэх зорилгоор зөвлөмж гаргах, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газартай хамтран “Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдал, хангамж, хүртээмжийг нэгдсэн цахим тогтолцоогоор хянах” боломжийг бүрдүүлэх.	-Улсын бүртгэлд бүртгэгдсэн эм, эмийн бүтээгдэхүүний ангиллын код, барааны бичиглэл бүхий зөвлөмж, мэдээллээр гаалийн харилцаанд оролцогчдыг ханган, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газраас олгодог мэдүүлэг /лиценз/ дэх мэдээллийг Licemed системээс CEPS систем рүү автоматаар real time байдлаар хүлээн авч, гаалийн бүрдүүлэлтийг хийдэг болсноор бичиг баримтын бүрдүүлэлтэд зарцуулах цаг хугацааг хэмнэх, хуурамч, дуураймал эм улсын хилээр нэвтрүүлэхээс урьдчилан сэргийлэх боломж бүрдэнэ.	- Хяналт, бүрдүүлэлтийн газар, - Барааны ангилал, үнэлгээний хэлтэс, - Санхүү, хөрөнгө оруулалтын газар, - Хорио цээрийн хэлтэс, - Мэдээллийн технологийн газар, - Олон нийттэй харилцах алба, - Харьяа гаалийн газар, хороод	Хяналт, бүрдүүлэлтийн газар
2	Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архи дан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 38.3 дахь заалтын хэрэгжилтийг хангах.	1. Импортлогч нараас: -гаалийн байгууллагад бүрдүүлж, илгээдэг бичиг баримтын тоо буурна; -ОАТТ авахаар ТЕГ-т хүсэлт гаргаж, баталгаажуулалт хийлгэх хугацааг багасгана. 2. Хилээр оруулсан согтууруулах ундааны хөдөлгөөнийг эцсийн хэрэглэгч хүртэл хянах системийн суурь тавигдана. 3. Онцгой албан татвартай барааны мэдээллийг ХХААХҮЯ, Татварын Ерөнхий газартай солилцсоноор хяналтыг сайжруулна.	- Хяналт, бүрдүүлэлтийн газар, - Санхүү, хөрөнгө оруулалтын газар, - Мэдээллийн технологийн газар, - Олон нийттэй харилцах алба, - Харьяа гаалийн газар, хороод	
3	Гаалийн хяналт, шалгалтад ашиглагдаж буй техник, тоног төхөөрөмжийн шинэчлэлт.	1.Булган боомтод суурилуулсан ИСБА рентгенээр чингэлэг, ачааны тээврийн хэрэгслийг шалгаж, хяналтыг сайжруулна. 2.Шивээхүрэн, Боршоо, Замын-Үүд боомтод суурилуулсан ИСБА рентгены програмд нэмэлт, өөрчлөлт оруулах хүсэлтийг ОХУ-ын ИСБА компанид хүсэлт хүргүүлж, шийдвэрлүүлнэ.	- Хяналт, бүрдүүлэлтийн газар, - Санхүү, хөрөнгө оруулалтын газар, - Мэдээллийн технологийн газар, - Олон нийттэй харилцах алба, - Харьяа гаалийн газар, хороод	

4	АТГ-ын МШХ-ээс ирүүлсэн мөрдөгчийн мэдэгдлийн хүрээнд гаалийн хяналт, шалгалтын үр дүнг нэмэгдүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулж ажиллах.	<ul style="list-style-type: none"> <li>-Энгэрийн камерыг ашиглахтай холбоотой видео зааврыг нийт албан хаагч нарт танилцуулна,</li> <li>-Рентгены сургалтад хамрагдсан болон дүрс зураг унших туршлагатай албан хаагч нараа түшиглэн гаалийн газар, хороод улиралд нэгээс доошгүй удаа сургалт зохион байгуулна,</li> <li>-Рентгенээр шалгасан чингэлэг, ачааны тээврийн хэрэгслийн зургийг барааны дагалдах бичиг баримтад тогтмол хавсаргана.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Хяналт, бүрдүүлэлтийн газар,</li> <li>- Санхүү, хөрөнгө оруулалтын газар,</li> <li>- Олон нийттэй харилцах алба,</li> <li>- Харьяа гаалийн газар, хороод.</li> </ul>	
5	Улсын хилээр хууль бусаар эд зүйл нэвтрүүлэхтэй тэмцэх чиглэлээр хийж хэрэгжүүлэх ажил	Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон болон хязгаарласан барааг хууль бусаар улсын хилээр нэвтрүүлэх гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, хэрэг, зөрчил илрүүлсэн үед хэрхэн хуульд нийцсэн арга хэмжээг цаг алдалгүй авч ажиллах чиглэлээр байгууллагын алба хаагчдын чадавхыг бэхжүүлэх, мэргэшүүлэхээс гадна гаалийн байгууллагад шинээр томилогдохоор чиглүүлэх сургалтад хамрагдаж буй алба хаагчдад гаалийн хяналт, шалгалт хийх, баргаа тээврийн хэрэгслийг нуувч болгон ашиглах эрсдэлтэй цэгүүдийг таньж мэдэх зэрэгт онол, практикийн хичээлийг хослуулан заах ач холбогдол бүхий VR сургалтын танхимыг 2023 оны 10 сарын 20-ны өдрөөс бүрэн ашиглалтад оруулан ажиллаж байна. Тус сургалтын танхимд одоо ажиллаж байгаа 328 албан хаагч, шинээр томилогдон ажиллахаар чиглүүлэх сургалтад хамрагдаж буй 134 албан хаагчийг сургаж, мэргэшүүлээд байна. Хууль бус бараа эргэлт тэр дундаа хар тамхи, мансууруулах бодис болон түүх соёлын дурсгалт зүйлс, буу, сум зэрэг хориглосон эд зүйлсийг бараа тээврийн хэрэгслийг нуувч болгон ашиглаж улсын хилээр нэвтрүүлэхийг завдсан хэрэг зөрчлийн илрүүлэлт нэмэгдэж энэ оны эхний 8 сарын байдлаар мансууруулах бодис хууль бусаар улсын хилээр нэвтрүүлэхийг завдсан 10, түүх соёлын дурсгалт зүйлсэд хамаарах 14 баринтаг судар, 318.9 килограмм мөнгө илрүүлэн ажиллаж байна.	<ul style="list-style-type: none"> <li>- Зөрчилтэй тэмцэх газар,</li> <li>- Санхүү, хөрөнгө оруулалтын газар,</li> <li>- Олон нийттэй харилцах алба,</li> <li>- Сургалтын төв,</li> <li>- Харьяа гаалийн газар, хороод</li> </ul>	Зөрчилтэй тэмцэх газар
6	Сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалт	2024 онд 3 удаагийн тусгай шалгалтаар 427 сул орон тоо зарласнаас 139 ажлыг байрыг нөөцөд байгаа иргэдээс авсан, мөн шилжин ажиллах зарын дагуу бусад байгууллагаас 29 албан хаагчийг шилжүүлэн авч, нийт 168 ажлын байрыг нөхсөн байна.	<ul style="list-style-type: none"> <li>- Хүний нөөцийн хэлтэс,</li> <li>- Санхүү, хөрөнгө оруулалтын газар,</li> <li>- Олон нийттэй харилцах алба,</li> <li>- Харьяа гаалийн газар, хороод</li> </ul>	Хүний нөөцийн хэлтэс
7	Хорио цээрийн хяналт шалгалтын үед ашиглах “Хяналтын хуудас”-ны цахимжуулалт.	Хорио цээрийн хяналт шалгалтын үед ашиглагдаж байсан цаасан суурьтай “Хяналтын хуудас”-уудыг хүчингүй болгон, цахимжуулж, 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрөөс мөрдөх шийдвэрийг гаргуулсан. ГЕГ-ын даргын 2024 оны 08 дугаар сарын 22-ны өдөр А/452 дугаартай тушаалаар зорчигчийн эрүүл мэндийн хуудсыг шинэчлэн батлуулсан байна. Цаасан суурьтай хяналтын хуудсыг хүчингүй болгосноор хэвлэлийн зардал, архивын нэгжийн тоог бууруулж, хяналт, шалгалтад ашиглагдах цаг хугацааг бууруулж, цахим суурьтай хяналтыг хийж, гадаад худалдааг хөнгөвчлөхөд ахиц гарна. Эрүүл мэндийн хуудсыг шинэчлэн баталснаар улсын хилээр нэвтрэх зорчигчийн хөдөлгөөн, урсгалыг нэмэгдүүлэхгүйгээр хурдан шуурхай бөглөх боломжийг бүрдүүлнэ.	<ul style="list-style-type: none"> <li>- Хорио цээрийн хэлтэс,</li> <li>- Санхүү, хөрөнгө оруулалтын газар,</li> <li>- Олон нийттэй харилцах алба,</li> <li>- Харьяа гаалийн газар, хороод</li> </ul>	Хорио цээрийн хэлтэс

8	Гадаад худалдааг хөнгөвчлөх, бичиг баримтын бүрдүүлэлтэд зарцуулах цаг хугацааг хэмнэх зорилгоор бичиг баримтын бүрдүүлэлтийн шатанд гаалийн үнийн хяналтыг цахимжуулах.	<ul style="list-style-type: none"> <li>- Суудлын автомашины гаалийн үнийг системээс автоматаар шалгах программыг хийж, 3 сарын хугацаанд туршсан байна.</li> <li>- “Суудлын автомашиныг системээс шалгах түр заавар” боловсруулж батлуулах.</li> <li>- Түр заавар батлагдаж, программыг нэвтрүүлснээр гаалийн бүрдүүлэлтэд зарцуулах цаг хугацаа болон ажлын ажлын ачаалал буурах, худалдааг хөнгөвчлөх, хүний нөөцийг зөв оновчтой хуваарилах, авлигаас ангид байх нөхцөл бүрдэнэ.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Барааны ангилал, үнэлгээний хэлтэс,</li> <li>- Мэдээллийн технологийн газар,</li> <li>- Бүрдүүлэлтийн цахим төв,</li> <li>- Олон нийттэй харилцах алба,</li> <li>- Харьяа гаалийн газар, хороод</li> </ul>	Барааны ангилал, үнэлгээний хэлтэс
9	Боомтын бүтээн байгуулалт.	<ul style="list-style-type: none"> <li>- Сэлэнгэ аймгийн Алтанбулаг боомтоор өдөрт нэвтрэх зорчигчийн тоо 2023 оны мөн үеэс 2 дахин, суудлын автомашины тоо 3 дахин, ачаа тээврийн хэрэгслийн тоо 1.5 дахин нэмэгдэнэ.</li> <li>- Увс аймгийн Боршоо боомтоор өдөрт нэвтрэх зорчигчийн тоо 2023 оны мөн үеэс 1.2 дахин, суудлын автомашины тоо 1.5 дахин, ачаа тээврийн хэрэгслийн тоо 1.2 дахин нэмэгдэнэ.</li> <li>- Өмнөговь аймгийн Гашуунсухайт боомтын өргөтгөл шинэчлэл хийгдэж дууссанаар боомтын нэвтрүүлэх хүчин чадал 3 дахин нэмэгдэнэ.</li> <li>- Сүхбаатар аймгийн Бичигт боомтын өргөтгөл шинэчлэл хийгдэж дууссанаар боомтын нэвтрүүлэх хүчин чадал 2.5 дахин нэмэгдэнэ.</li> <li>- Замын-Үүд боомтыг 24 цагийн горимд шилжүүлснээр 2024 оны 10 сарын 01-ний өдрөөс 2024 оны 12 сарын 31 хүртэл нийт 43 мянган тээврийн хэрэгсэл /ачааны/ нэвтэрсэн байна. Үүнээс:          Өдрийн цагаар 29 мянган тээврийн хэрэгсэл /ачааны/          Шөнийн цагаар 14 мянган тээврийн хэрэгсэл /ачааны/ нэвтэрсэн байна.          24 цагийн горимд шилжүүлснээр ачаа тээврийн хэрэгслийн ачаалал ойролцоогоор 40 орчим буурсан байна.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Боомтын хэлтэс,</li> <li>- Санхүү, хөрөнгө оруулалтын газар,</li> <li>- Олон нийттэй харилцах алба,</li> <li>- Харьяа гаалийн газар, хороод</li> </ul>	Боомтын хэлтэс
10	Дотоод хяналт, аюулгүй байдлын хэлтсийг шинээр байгуулсан.	<ul style="list-style-type: none"> <li>- Гаалийн байгууллагын үйл ажиллагаа, албан хаагчтай холбоотой гомдол, мэдээллийг хүлээн авч, хуульд заасан хугацаанд шалгаж, шийдвэрлэсэн байна.</li> <li>- Харьяа гаалийн газар, хороодтой онлайн групп нээж, цаг үеийн мэдээллийг шуурхай авч, танилцуулсан байна.</li> <li>- Албан хаагчид холбогдох зөрчлийн үйлдлийг шалгаж, хариуцлага тооцох саналыг Сахилгын хороонд хүргүүлсэн байна.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Дотоод хяналт, аюулгүй байдлын хэлтэс,</li> <li>- Санхүү, хөрөнгө оруулалтын газар,</li> <li>- Олон нийттэй харилцах алба,</li> <li>- Харьяа гаалийн газар, хороод</li> </ul>	Дотоод хяналт, аюулгүй байдлын хэлтэс
11	Байгууллагын дотоод шударга байдлыг нэмэгдүүлэх зорилгоор албан хаагчдыг нууц санал асуулгад хамруулж, үр дүнг тооцох.	Байгууллагын дотоод шударга байдлыг нэмэгдүүлэх санал асуулгын хуудас бэлтгэж, албан хаагчдыг нууц санал асуулгад хамруулж, үр дүнд дүн шинжилгээ хийж, танилцуулсан байна.	<ul style="list-style-type: none"> <li>- ГЕГ-ын зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллагууд,</li> <li>- Харьяа гаалийн газар, хороод</li> </ul>	Дотоод хяналт, аюулгүй байдлын хэлтэс

12	Бүрдүүлэлтийн цахим төвийг шинээр байгуулсан.	<p>- Монгол улсын Сангийн сайдын 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн “Гаалийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтэц, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай” 06 дугаар тушаалаар “Бүрдүүлэлтийн цахим төвийн үндсэн чиг үүргийг батлан, шинээр байгуулсан.</p> <p>1. Гаалийн ерөнхий газар болон харьяа 20 гаалийн газар, хорооны импортын барааны бичиг баримтын хяналтыг нэг цэгт төвлөрүүлэн бичиг баримтын бүрдүүлэлт хийж эхэлсэн.</p> <ul style="list-style-type: none"> <li>✓ Гадаад худалдаанд оролцож байгаа ААН, иргэн цаг хугацаа, орон зайнаас үл хамааран барааг ӨӨРӨӨ МЭДҮҮЛЭХ эсхүл гаалийн ЗУУЧЛАГЧААР ДАМЖУУЛЖ <a href="http://www.gaali.mn">www.gaali.mn</a> системийг ашиглаж гаалийн байгууллагын КАИС системд мэдүүлэг илгээдэг.</li> <li>✓ Гаалийн байгууллага гаалийн бүрдүүлэлтийг хялбарчлах, хяналтыг боловсронгуй болгож үр нөлөөг дээшлүүлэх, гаалийн бүрдүүлэлтийн цаг хугацаа, зардлыг багасгах, хүний нөөцийг оновчтой хуваарилах байдлаар хууль ёсны олон улсын худалдааг хөнгөвчлөх зорилтыг хэрэгжүүлж байна.</li> </ul> <p style="text-align: center;"><b><u>Гарч буй үр дүн эерэг нөлөө- ААН;</u></b></p> <ul style="list-style-type: none"> <li>✓ Гаалийн бүрдүүлэлтэд зарцуулах цаг хугацаа, зардлыг бодитойгоор бууруулсан “Хууль ёсны худалдааг дэмжиж, гадаад худалдааг үе шаттайгаар хөнгөвчилсэн,- <i>Бичиг баримтын бүрдүүлэлтэд зарцуулсан дундаж цаг хугацааг өмнөх оны мөн үеэс 1.5 хувиар бууруулсан байна.</i></li> <li>✓ Бүрдүүлэлтийн үед нүүр тулсан харилцааг буурч, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх нөхцөлийг бүрдүүлсэн;</li> <li>✓ Гаалийн хууль тогтоомжийг нэг мөр хэрэгжүүлж, гадаад худалдааг эрхлэгчдэд зөвлөмж, мэдээллийг шуурхай тэгш хүртээмжтэй байдлаар хангах, шударга өрсөлдөх нөхцөлийг хангасан;</li> <li>✓ Гадаад худалдааны бичиг баримтыг гаалийн зорилгоор нягтлан шалгах шат дамжлага цөөрснөөр бараа гаалийн байгууллаас хүлээн авах хугацаа буурсан;</li> <li>✓ Цаашид барааг хиймэл оюун ухаан, технологийн дэвшлийг ашиглан барааны гаалийн бүрдүүлэлтийг автоматаар хийж гүйцэтгэх боломжийг бүрдүүлсэн,</li> </ul> <p style="text-align: center;"><b><u>Гаалийн байгууллагын хувьд</u></b></p> <ul style="list-style-type: none"> <li>✓ Олон улсын жишигт нийцсэн гаалийн үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн;</li> <li>✓ Гаалийн байгууллага хоорондын ажлын уялдаа холбоо сайжирч, ажлын байрны давхардал буурах;</li> <li>✓ Хүний нөөцийн оновчтой хуваарилан зохион байгуулснаар, гаалийн улсын байцаагчийг мэргэшүүлэх боломж бүрдэж байна;</li> </ul>	<p>- Бүрдүүлэлтийн цахим төв,  - Санхүү, хөрөнгө оруулалтын газар,  - Олон нийттэй харилцах алба,  - Харьяа гаалийн газар, хороод</p>	Бүрдүүлэлтийн цахим төв
----	---	---	---	-------------------------

		✓ Гаалийн бүрдүүлэлтийн горимын шаардлага, барааны ангилал, гаалийн үнийн хяналтын тогтолцоог нэгдмэл сайжруулахад нөлөөлсөн;		
13	Эрэлч нохойг гаалийн хяналт шалгалтад ашиглаж буй байдлыг сайжруулах.	Гаалийн хяналт шалгалтад ашиглах эрэлч нохдыг нэмэх зорилгоор хориглосон хязгаарласан бараа бүтээгдэхүүн, хар тамхи мансууруулах бодис зэргийг таньж илрүүлэх ЭНСТ-ийн анхан болон давтан сургалтуудыг явуулсан. 2024 он гарснаар анхан шатны сургалт 4, давтан сургалт 1, ажлын байран дахь сургалт 1 удаа хийгдсэн. Нийт 20 нохойг сургалтад хамруулж газар хороод руу явуулсан. 2024 оны 9 сарын байдлаар эрэлч нохой ашиглан илрүүлсэн зөрчлийн тоо 24 байна. Үүнээс 1 сард 3 зөрчил, 3 сард 2 зөрчил, 4 сард 5 зөрчил, 5 сард 4 зөрчил, 6 сард 4 зөрчил, 8 сард 3 зөрчил, 9 сард 3 зөрчил илрүүлсэн байна. 2023 онд жилийн эцсээр нийт 20 зөрчил илрүүлсэн байсан ба 2024 онтой харьцуулахад ахисан үр дүнтэй байна. Мөн гаалийн газар хороодод ажиллаж байгаа Эрэлч нохой хариуцсан ГУАБ-3, ГУБ- 29, ЭНХ- 7 байна.	- Эрэлч нохойн сургалтын төв, - Санхүү, хөрөнгө оруулалтын газар, - Олон нийттэй харилцах алба, - Харьяа гаалийн газар, хороод	Эрэлч нохойн сургалтын төв
14	“Бараанаас сорьц, дээж, загвар авах, магадлан шинжилгээ хийх, дүгнэлт гаргах журам”-ын нэмэлт, өөрчлөлтийг боловсронгуй болгох.	- Бараанаас сорьц, дээж, загвар авах, магадлан шинжилгээ хийх, дүгнэлт гаргах журам”-ын нэмэлт өөрчлөлт оруулан, шинэчлэн батлуулсан байна. Журам хэрэгжиж эхэлснээр шинжилгээнд зарцуулагдах цаг хугацаа ААН-үүдэд тодорхой болж, дүгнэлтийн цахимаар гаргаж, баталгаажуулснаар ААН-үүд цаасан хувилбарыг авах шаардлагагүй болж, гадаад худалдааг хөнгөвчлөн, гаалийн байгууллагаас үзүүлж буй үйлчилгээг түргэн шуурхай болно. - Гаалийн бүрдүүлэлтэд зарцуулах цаг хугацааг 1-2 хоногоор хэмнэх.	- Гаалийн төв лаборатори, - Эрэлч нохой сургалтын төв, - Санхүү, хөрөнгө оруулалтын газар, - Олон нийттэй харилцах алба, - Харьяа гаалийн газар, хороод	Гаалийн төв лаборатори
15	Гаалийн байгууллагын албан хаагчтай холбоотой гомдол, мэдээллийг хүлээн авах “Гаалийн лавлах 1800-1281” дугаарын утсыг олон нийтэд сурталчлах зорилгоор наалт бүхий хуудасны эх загварыг гаргаж, хэвлүүлэх.	“Гаалийн лавлах 1800-1281” дугаарын утсыг олон нийтэд сурталчлах наалт бүхий хуудасны эх загварыг батлуулж эх загварыг хэвлүүлсэн байна.	- Санхүү, хөрөнгө оруулалтын газар, - Олон нийттэй харилцах алба	Олон нийттэй харилцах алба
16	“Цахим системд үүсч буй хүндрэл бэрхшээл” сэдвээр Татварын ерөнхий газар, ГТСМТТөв УҮГ-тай хамтарч хэлэлцүүлэг зохион байгуулах.	Сангийн яам, Гаалийн ерөнхий газар, Татварын ерөнхий газарт нэвтрүүлэн ашиглаж байгаа цахим системийн ашиглалттай холбоотой иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас гаргаж байгаа өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг шийдвэрлэх, цахим системд үүсч байгаа хүндрэл, бэрхшээлийг арилгах чиглэлээр хамтран “Хэлэлцүүлэг” зохион байгуулан шийдвэрлэх ажлыг 2024 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган оролцох, энэ талаар Сангийн яам, Гаалийн ерөнхий газар, Татварын ерөнхий газрын ЭБАТ бүгд санал нэгдсэн.	- Санхүү, хөрөнгө оруулалтын газар, - Мэдээллийн технологийн газар, - Олон нийттэй харилцах алба	Мэдээллийн технологийн газар

		<p>“Хэлэлцүүлэг”-ийн үр дүнг үндэслэн “Санхүүгийн мэдээллийн технологийн төв” УТҮГ нь “Технологийн шийдэл тодорхойлох процесс зураглал”, “Хөгжүүлэлтийн шийдэл тодорхойлох процесс зураглал”, “Систем хөгжүүлэлт хийх процесс зураглал”, “Алдаа засвар хийх процесс зураглал”-ын дагуу аль болох түргэн хугацаанд шийдвэрлэгдэх тул зохих саналаа ирүүлэхийг хүссэн.</p> <p>Хэлэлцүүлэг хэсэгт МТГ-аас дараах саналыг хүргүүлэхээр бэлтгэсэн.</p> <p>1. Гааль, татварын байгууллагын мэдээллийн системийг уялдуулан хийгдсэн програм хангамж, системийн талаар хэлэлцэж гарч буй гол асуудлыг шийдвэрлэх. Үүнд: 2024 оны 01 дүгээр сарын 01-ээс гаалийн байгууллагад хоёр байгууллагын мэдээллийн системтэй холбоотой ирж буй санал, гомдол “Уул уурхайн бүтээгдэхүүний гэрээ бүртгэлийн нэгдсэн систем-65”, “тээврийн гэрээ-16”, гаалийн байгууллагаас илгээж буй мэдүүлгийн “татварын системд бүрэн татагдаж буй эсэх буюу татварын НӨАТ-ын мэдээлэл татагдахгүй байгаа -120” бүртгэгдсэн байна.</p> <p>2. Гаалийн байгууллагаас өгч буй тусгай зөвшөөрлийн цахим системийн ашиглалт гарч тулгамдаж буй асуудал.</p> <p>3. Гурван байгууллагын түвшинд шинээр нэвтрүүлж буй системүүдэд гарч болох хүндрэл тухайн асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар санал солилцох.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Онцгой албан татварын тэмдэгтийг гаалийн бүрдүүлэлтэд бүртгэх</li> <li>• Экспорт, импортын гаалийн бүрдүүлэлт хийж буй барааны баркод оруулах буюу СМТТ УТҮГ-ын мэдээллийн сангаас татах</li> <li>• Хойшлуулсан татварын төлөлтийн мэдээлэл солилцох.</li> </ul> <p>Мөн Хяналт бүрдүүлэлтийн газар, Барааны ангилал, үнэлгээний хэлтэст 2024.09.24-ны өдөр тус хэлэлцүүлэгт оруулах програмтай холбоотой санал, гомдлыг ангилж ирүүлэх тухай дотоод зурвасаар хүргүүлсэн. Уулзалт зохион байгуулахтай холбоотой хэлэлцүүлэгт гаалийн байгууллагаас тавих асуудлыг багцлан АТГ-ын холбогдох албан хаагчид хүргүүлсэн.</p>		
17	<p>Авлигаас ангид байхад чиглэсэн сургалт, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах.</p>	<p>ГЕГ-ын холбогдох нэгжүүдээс харьяа гаалийн газар хороодын үйл ажиллагаанд анхаарах асуудлын хүрээнд сургалт уулзалтуудыг зохион байгуулан ажилласан. Гаалийн байгууллагын нэр хүндийг өндөрт өргөн ажиллах, Албан хаагчид ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлж, авлигаас ангид байх, бүх шатны удирдах албан хаагчдыг гүйцэтгэх албан тушаалтанд тавих хяналтаа сайжруулах, энэ төрлийн хэрэгт албан хаагчид өртөхөөс урьдчилан сэргийлж ажиллах талаар ГЕГ-ын дэргэдэх БЦТ, харьяа гаалийн газар, хороодоос УБГГ, ЗҮГГ, ДаГГ, СэгГ, УХШИГГ, ЧХОУНБГГ, ОргГ-ын албан хаагчидад мэдээлэл хийсэн.</p>	<p>- Зөрчилтэй тэмцэх газар, - Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар, - Хуулийн хэлтэс, - Сургалтын төв, - Олон нийттэй харилцах алба</p>	<p>Олон нийттэй харилцах алба</p>

18	Ёс зүйн дэд хорооны ажлыг эрчимжүүлэх.	<ul style="list-style-type: none"> <li>- ДГБ-ын “Гаалийн байгууллагын ёс зүйн үнэлгээ” хийх зааврыг орчуулна.</li> <li>- Гаалийн албан хаагч болон хувийн хэвшлээс санал асуулга авна.</li> <li>- “Гаалийн улсын байцаагчийн ёс зүйн дүрэм”-ийг шинэчилнэ.</li> <li>- Байгууллагын өөрийн үнэлгээ хийхэд дэмжлэг үзүүлнэ.</li> <li>- ГЕГ болон харьяа гаалийн газар, хороодын дэргэдэх 20 Ёс зүйн дэд хорооны хамтарсан уулзалтыг зохион байгуулж, ДГБ-ын Ёс зүй, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх чиглэлээр гаргасан бодлогын баримт бичгийн талаар танилцуулан, ДГБ-ын Ёс зүйн дүрэм боловсруулах загварыг орчуулж, Монголын Гаалийн байгууллагын Ёс зүйн дүрэмтэй харьцуулж, Ёс зүйн дэд хороодын ажиллах зарчмыг тодорхойлно</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Ёс зүйн дэд хороо,</li> <li>- Олон нийттэй харилцах алба</li> </ul>	Ёс зүйн дэд хороо
19	Арга хэмжээний нотломжийг тайланд хавсаргаж ирүүлэх.	ГЕГ-ын ЗББНДБ-ууд болон харьяа гаалийн газар, хороодоос арга хэмжээ тус бүрийн тайланг нотломжийн хамт авсан байна.	<ul style="list-style-type: none"> <li>- ГЕГ-ын ЗББНДБ-ууд,</li> <li>- Харьяа гаалийн газар, хороо</li> </ul>	Захиргааны удирдлагын газар
20	Арга хэмжээ тус бүрийг олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулах.	<ul style="list-style-type: none"> <li>- Олон нийтэд түгээсэн байна,</li> <li>- Гаалийн байгууллагын 1800-1281 дугаар, Авлигыг мэдээлэх 110 дугаарын утсыг сурталчилсан байна.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Захиргааны удирдлагын газар,</li> <li>- Олон нийттэй харилцах алба,</li> <li>- Харьяа гаалийн газар, хороо</li> </ul>	Олон нийттэй харилцах алба

Төлөвлөгөөг 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 11 дүгээр сарын 30-ны өдрийн хугацаанд хэрэгжүүлэн биелэлтийг 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор холбогдох нотломжийн хамт Захиргааны удирдлагын газарт ирүүлэх.

## ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР